



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2023/187/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улиастай сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-Undraa@audit.gov.mn">Bat-Undraa@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a>  Ахлах аудитор: Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: <a href="mailto:jalbaab@audit.gov.mn">jalbaab@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

Харгааралттай дүгнэлт № 61

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

### ХЯЗГААРЛАЛТТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, хурлын хороодын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө анхан шатны баримтгүй, хорооны гишүүдийн хувийн дансанд шилжүүлсэн, авто тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх зориулалтаар худалдан авсан сэлбэгийг данс бүртгэлд тусгаагүй, шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4 дүгээр зүйлийн 4.20-д "төсөвт байгууллага нь бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана", 4.21-д "бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

2023.12.15

Завхан аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиосон байна.

#### **Аудитын гол асуудал**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь он дамжсан авлагыг барагдуулаагүй, төлөөлөгч нарын тойрогт ажиллах зардлыг хувийн дансанд шилжүүлсэн нь шинж чанарын хувьд материаллаг байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансны цахим мэдээллийн системд нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан орлого, зардлыг мэдээлээгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  


Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,319,528.55</b>	<b>28,571,071.55</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,137,528.55	21,128,571.55
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,137,528.55	21,128,571.55
3351	Байгууллагаас авах авлага	2,137,528.55	21,128,571.55
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	6,182,000.00	7,442,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	6,182,000.00	7,442,500.00
35410	Бичиг хэргийн материал	440,000.00	440,000.00
35420	Аж ахуйн материал	5,192,000.00	4,822,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	550,000.00	2,180,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>105,670,930.70</b>	<b>174,545,432.60</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	105,670,930.70	174,545,432.60
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	65,000,000.00	65,000,000.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	-15,031,250.37	-16,656,250.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	110,000,000.00	74,000,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-110,000,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	62,973,690.00	70,942,515.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-13,873,689.97	-23,459,044.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	23,004,525.12	21,999,525.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-16,402,344.08	-17,281,312.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	680,000.00	480,000.00
39301	Програм хангамж	-680,000.00	-480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	<b>113,990,459.25</b>	<b>203,116,504.15</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,039,062.56</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	2,039,062.56	00.00
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,039,062.56	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,039,062.56	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	<b>111,951,396.69</b>	<b>203,116,504.15</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	111,951,396.69	203,116,504.15
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	98,985,450.00	98,985,450.00
51101	Өмч: - төрийн	98,985,450.00	98,985,450.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,595,432.05	95,760,542.51
51210	Өмнөх үеийн үр дүн	4,595,432.05	4,595,435.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	91,165,107.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,370,514.64	8,370,511.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>113,990,459.25</b>	<b>203,116,504.15</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,203,114,200.00</b>	<b>1,146,187,700.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	74,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	74,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	74,000,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,203,114,200.00</b>	<b>1,072,187,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	943,184,200.00	1,021,187,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	943,184,200.00	1,021,187,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	259,930,000.00	51,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	249,000,000.00	40,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,930,000.00	11,000,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,187,705,968.05</b>	<b>1,055,022,592.54</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,187,705,968.05</b>	<b>1,055,022,592.54</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,132,880,085.97	1,027,592,109.17
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	188,918,115.41	336,396,428.82
210101	Үндсэн цалин	127,759,740.82	193,170,408.01
210102	Нэмэгдэл	40,190,856.99	98,970,919.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,828,500.00	17,163,000.00
210104	Урамшуулал	10,912,255.60	10,229,062.15
210105	Гэрээт ажлын хөлс	226,762.00	16,863,038.70
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,158,931.10	42,008,135.65
210201	Тэтгэврийн даатгал	16,539,195.67	29,173,202.14
210202	Тэтгэмжийн даатгал	1,945,883.86	3,432,141.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,518,067.12	2,692,913.10
210204	Ажилгүйдлийн даатгал	378,256.75	609,989.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,777,527.70	6,099,889.90
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	54,991,446.05	64,153,487.60
210401	Бичиг хэрэг	2,511,490.00	3,333,890.00
210402	Тээвэр, шатахуун	38,888,700.00	50,757,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,466,056.05	3,293,447.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,125,200.00	6,769,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,164,900.00	38,500,200.00
210604	Урсгал засвар	27,164,900.00	38,500,200.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	10,670,000.00	16,987,100.00
210702	Дотоод албан томилолт	10,670,000.00	16,987,100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	703,397,337.92	408,676,694.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	701,516,397.92	402,946,750.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,641,800.00	1,238,600.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,140.00	362,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,106,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,579,355.49	120,870,063.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,596,150.00	68,227,440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,267,900.00	31,677,410.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,715,305.49	20,965,213.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,825,882.08	27,430,483.37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	33,832,588.08	22,571,483.37
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,832,588.08	22,571,483.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,993,294.00	4,859,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,788,694.00	4,859,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,204,600.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>15,408,231.95</b>	<b>91,165,107.46</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,120,999.82	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,120,999.82	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,120,999.82	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>9,287,232.13</b>	<b>91,165,107.46</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,203,114,200.00</b>	<b>1,072,187,700.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,203,114,200.00</b>	<b>1,072,187,700.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	943,184,200.00	1,021,187,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	943,184,200.00	1,021,187,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	259,930,000.00	51,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	249,000,000.00	40,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,930,000.00	11,000,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,176,780,700.00</b>	<b>1,056,347,985.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,176,780,700.00</b>	<b>1,056,347,985.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,120,954,817.92</b>	<b>1,028,917,501.63</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,918,115.41	336,396,428.82

210101	Үндсэн цалин	127,759,742.18	195,853,426.37
210102	Нэмэгдэл	40,190,856.99	98,970,920.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,828,500.00	17,163,000.00
210104	Урамшуулал	10,912,255.60	10,229,062.15
210105	Гэрээт ажлын хөлс	226,760.64	14,180,020.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,158,931.10	42,008,135.65
210201	Тэтгэврийн даатгал	16,539,195.67	29,173,202.14
210202	Тэтгэмжийн даатгал	1,945,883.86	3,432,141.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,518,067.12	2,692,913.10
210204	Ажилгүйдлийн даатгал	378,256.75	609,989.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,777,527.70	6,099,889.90
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,718,546.05	55,654,637.60
210401	Бичиг хэрэг	2,274,990.00	3,333,890.00
210402	Тээвэр, шатахуун	33,464,200.00	43,464,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,466,056.05	3,293,447.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,513,300.00	5,563,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,334,900.00	40,130,200.00
210604	Урсгал засвар	27,334,900.00	40,130,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,670,000.00	16,987,100.00
210702	Дотоод албан томилолт	10,670,000.00	16,987,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	707,606,275.36	435,167,249.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	705,725,335.36	429,437,305.56
210803	Даатгалын үйлчилгээ	1,641,800.00	1,238,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,140.00	362,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,106,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	111,548,050.00	102,573,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,027,150.00	67,574,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,520,900.00	34,999,410.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,825,882.08</b>	<b>27,430,483.37</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	33,832,588.08	22,571,483.37
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	33,832,588.08	22,571,483.37
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	21,993,294.00	4,859,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,788,694.00	4,859,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,204,600.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>26,333,500.00</b>	<b>15,839,715.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>26,333,500.00</b>	<b>15,839,715.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,333,500.00</b>	<b>15,839,715.00</b>

2200	Дотоод эх үүсвэрээр	26,333,500.00	15,839,715.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,333,500.00	15,839,715.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-26,333,500.00</b>	<b>-15,839,715.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

I

СТ-4А

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,419,234.64	-33,818,159.95	73,586,524.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	48,720.00	48,720.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,985,450.00	8,419,234.64	-33,769,439.95	73,635,244.69
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,077,639.87	29,077,639.87
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,370,514.64	4,595,432.05	111,951,396.69
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,370,514.64	4,595,432.05	111,951,396.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	03.00	03.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,985,450.00	8,370,514.64	4,595,435.05	111,951,399.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-03.00	00.00	-03.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	91,165,107.46	91,165,107.46
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,370,511.64	95,760,542.51	203,116,504.15

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,021,187,700.00	998,616,216.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,021,187,700.00	998,616,216.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,016,187,700.00	993,757,216.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,298,100.00	336,396,428.82
210101	Үндсэн цалин	198,016,600.00	195,853,426.37

210102	Нэмэгдэл	123,593,500.00	98,970,920.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,688,000.00	17,163,000.00
210104	Урамшуулал	00.00	10,229,062.15
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	14,180,020.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,412,300.00</b>	<b>42,008,135.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,840,300.00	29,173,202.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,393,000.00	3,432,141.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,714,400.00	2,692,913.10
210204	Ажилгүйдлийн даатгал	678,600.00	609,989.06
210205	Эрүүл мэндийн даатгал	6,786,000.00	6,099,889.90
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>58,442,200.00</b>	<b>58,294,452.60</b>
210401	Бичиг хэрэг	3,275,000.00	3,333,890.00
210402	Тээвэр, шатахуун	43,464,200.00	43,464,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,000.00	3,293,447.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,103,000.00	8,202,915.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,334,000.00</b>	<b>40,130,200.00</b>
210604	Урсгал засвар	44,334,000.00	40,130,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>20,224,000.00</b>	<b>16,987,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	20,224,000.00	16,987,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>408,819,000.00</b>	<b>397,367,149.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	392,272,000.00	382,637,205.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,641,000.00	1,238,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	362,664.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,880,000.00	13,106,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>102658100.00</b>	<b>102573750.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,658,100.00	67,574,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,000,000.00	34,999,410.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5000000.00</b>	<b>4,859,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,000,000.00</b>	<b>4,859,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	4,859,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,021,187,700.00</b>	<b>1,021,187,700.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,021,187,700.00</b>	<b>1,021,187,700.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,021,187,700.00	1,021,187,700.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,000,000.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,000,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага мөн юм.

Тус байгууллага нь 2023 онд 4 зорилтын хүрээнд 75 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, биелэлт 94 хувьтай байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89.1 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,137.5	21,128.6	18,991.1
Бараа материал	6,182.0	7,442.5	1,260.5
Үндсэн хөрөнгө	105,670.9	174,545.4	68,874.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>113,990.5</b>	<b>203,116.5</b>	<b>89,126.0</b>
Өр төлбөр	2,039.1	0	-2,039.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	111,951.4	203,116.5	91,165.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>113,990.5</b>	<b>203,116.5</b>	<b>89,126.0</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас худалдан авсан багаж, техник хэрэгсэл нийлүүлэгдээгүй,
- ✓ Бараа материалын үлдэгдэл өссөн нь оны эцэс авто машины дугуй худалдан авч нөөцөлсөн,
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас балансаас балансад авто тээврийн хэрэгсэл шилжүүлэн авсан, төсвийн хөрөнгөөр 15.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж тавилга худалдан зэрэгтэй тус тус холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 287.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үндсэн үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгаа, зөвлөл хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс, биеийн тамир уралдаан тэмцээн, сургалт семинар, ажил олгогчоос олох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гэсэн 6 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,021.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,021.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 22.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, гүйцэтгэл 97.8 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	575,515.7	566,852.3	8,663.4	98.5
2	Мэдээлэл сурталчилгаа	5,258.1	5,220.0	38.1	99.3
3	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	234,000.0	220,603.8	13,396.2	94.3
4	Биеийн тамир уралдаан тэмцээн	22,000.0	18,329.0	3,671.0	83.3
5	Сургалт, семинар	26,400.0	29,988.7	-3,588.7	113.6
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,000.0	4,609.0	391.0	92.2
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	153,013.8	153,013.8	0	100
	<b>ДҮН</b>	<b>1,021,187.6</b>	<b>998,616.6</b>	<b>22,571.0</b>	<b>97.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 51.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд энэ нь цагаатгалын нөхөн төлбөр 40.0 сая, хамтарсан багийн санхүүжилт 11.0 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 2/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлаар сонгож 1,187.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 1,055.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардал, шатахууны зардлыг өссөн дүнгээр мэдээлээгүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн аудитаар ажлаас чөлөөлөгдсөн алба хаагчид тэтгэмж олгосон 1.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,172.2	1	1,172.2	100
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,172.2</b>	<b>1</b>	<b>1,172.2</b>	<b>100</b>

Шийдвэрийн биелэлтийг FAS системд бүртгэсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 93.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Байгууллагаас авах авлагын бичилт буруу хийсэн 19.0 сая,
- ✓ Балансаас балансад шилжин ирсэн авто тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй орлогоор бүртгээгүй 74.0 сая төгрөг байна.

Аудитаар нийт 250.3 сая төгрөгийн зөрчил илэрсний 7.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 242.9 сая төгрөгийн зөрчил зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын үйл ажиллагаанд зориулан төсөв баталж зориулалт бус зарцуулсан, зарцуулалт нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, зарим хөрөнгийг хороодын гишүүд хувийн дансанд шилжүүлэн авсан 7.4 сая төгрөгийн зөрчил байна.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим мэдээллийг санд нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардал, шатахууны зардлыг өссөн үзүүлэлтээр мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтууд, стандартын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн дансны орлого зардал, үйл ажиллагааны зардлыг өссөн дүнгээр мэдээлж байх

1.2 Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 8.0 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалт, стандартын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөс аливаа хэлбэрээр бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх

1.3 Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авсан байна. Ингэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 10.1 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

заалт, стандартын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авах чиглэл баримталж ажиллах

1.4 Илрүүлэлт: Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр баталж, уг хөтөлбөрийн хүрээнд алба хаагчдын дархлаа дэмжих нэрээр хүн бүрд жимс өгсөн 1.2 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэсэн заалт, стандартын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аливаа хэлбэрээр дүрэм, журам, хөтөлбөр боловсруулахдаа холбогдох хуульд нийцүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх

## **2. Нягтлан бодох бүртгэлтэй, тайлагналтай холбоотой**

2.1 Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгсэлд засвар хийх зорилгоор худалдан авсан сэлбэг хэрэгслийг данс бүртгэлд тусгаагүй, баримтын бүрдүүлэлт хангалтгүй 19.4 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3-д “Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх заавар” гэсэн заалтууд, стандартын иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан материалыг тооцооны дансаар дамжуулан, бараа материалын тодруулга тайланд тусгаж байх

2.2 Илрүүлэлт: Он дамжсан, насжилт өндөртэй 2.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт, стандартын эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах

## **3. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой**

3.1 Илрүүлэлт: Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн тойрогт ажиллах зардлыг төлөөлөгч нарын хувийн дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан “ Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8-д “ төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын

хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөөлөгчийн зардлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хувийн дансанд шилжүүлдэг зөрчлийг давтан гаргахгүй байх

3.2 Илрүүлэлт: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн хурлын хэрэгцээнд ус ундаа, чихэр жимс худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан 5.2 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт, стандартын тохилдсон байх, зохистой бөгөөд нийцсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хэрэгцээнд зориулан ус, ундаа, чихэр, жимс худалдан авч, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг давтан гаргахгүй байх

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



